

Бодлогын судалгааны ном зохиол судлал

Сэдэв: АЙМАГ, СУМЫН ИТХ-Д БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ, ШИЙДВЭР ГАРГАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭЭШЛҮҮЛЭХ НЬ

ИРГЭДИЙН ОРОЛЦОО ХЭМЭЭХ ОЙЛГОЛТЫН ТУХАЙД

Иргэдийн оролцооны асуудал нь төр иргэн хоёрын харилцааны хүрээнд яригдах асуудал мөн. Төр нь иргэдтэйгээ олон улсын, үндэсний, орон нутгийн гэсэн түвшинд харилцаж байхаас гадна, иргэд төртэй хувь хүнийхээ хувьд юмуу эсвэл иргэний нийгмийн байгууллагууд хэмээх зохион байгуулагдсан бүлэглэлд оролцогчийн хувиар төртэй харилцдаг. Мөн төлөөллийн ардчилал нь сонгуулиудын завсар хооронд төр болон иргэдийн хооронд явагдаж байдаг харилцаанд тулгуурладаг. /9/

Иргэдийн улс төрд оролцох оролцоо сонгуульд санал өгснөөр дуусгавар болохгүй. Өөрсдийг нь төлөөлж буй байгууллага болон төлөөлөгчид хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, шаардлага тавих, нөлөө үзүүлэх зэрэг бүх хэлбэрээр өрнөх хэрэгтэй. Төлөөллийн ардчиллын үед иргэдийг төлөөлж, иргэдийн өмнөөс шийдвэр гаргаж буй хүн ямар шийдвэр гаргаж байгаа нь, ямар шийдвэрийн төлөө саналаа өгч байгаа нь иргэдэд хамгийн их хамаатай. Иргэдийн ашиг сонирхол, үзэл бодлыг хүндэтгэж, шийдвэр гаргахдаа харгалзаж байгаа эсэхийг иргэд мэддэг байх ёстой. /25/

Иргэдийн оролцоо нь иргэдийн зүгээс улс төрийн системийн бүх түвшинд шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх үйл ажиллагаа. /25/

Нийгмийн хөгжлийн шинэ хандлага бол нийгмийн хариуцлага бөгөөд засгийн газар хөрөнгийг оновчтой, ил тод зарцуулж, нутгийн иргэдийн хэрэгцээг хангаж байгаа эсэхийг шалгаж хянах үүднээс иргэд өөрсдөө хамтран ажиллах явдал юм. Төрийн үйлчилгээг шаардах, сайжруулахад иргэд өөрсдөө гол хүчин байх болно. /26/

Ардчиллын суурь зарчим бол иргэд хариуцлагыг шаардах, төрийн албаны хүмүүс хариуцлага хүлээх үүрэгтэй байх явдал юм. Ардчиллын шинэ давалгаа бол иргэний оролцоонд тулгуурласан засаглал, иргэний дуу хоолойгоор хариуцлага бий болгох гэж үзэхэд чиглэж байна. Ардчиллын хөгжлийг авч үзэх юм бол засаглалд эхэн үедээ дан ганц төрийн аппаратуудаар /хууль, шүүх, цагдаа, хяналтын алба/ дамжсан хяналтын тогтолцоотой байсан, дараа нь хараат бус байгууллагуудыг /омбудсман, авилгын хороо г.м/ байгуулж эхэлсэн, харин сүүлийн үеэс иргэдийн дуу хоолой, чадавхийг нэмэгдүүлэх замаар төрийн албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх болсон байна. /27/

Иргэдийн оролцоо гэдэг нь олон түмнийг нийгмийн амьдралд эзэн ёсоор оролцуулах арга зам, улс төрийн соёлын нэгэн хэсэг, соёл иргэншлийн онцлогыг харуулагч нэг үзүүлэлт мөн бөгөөд тухайн улсын ардчилалын агуулга, хэлбэр, хөгжлийнт түвшинг илтгэж байдаг. /28/

Иргэдийн оролцоо гэдэг нь нийгмийн хөгжлийн асуудлаар бодлого, шийдвэр гаргах болон хэрэгжүүлэхэд оролцооны олон хэлбэрээр нөлөөлж, хяналт тавих үйл явцыг хэлнэ. /29/

НУТГИЙН ӨӨРИЙН УДИРДЛАГА БА ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ УЧИР ХОЛБОГДОЛ

Нутгийн өөрөө удирдах ёсны ач холбогдол нь ардчилал хөгжих / иргэд НӨУБ-ын үйл ажиллагаанд идэвхитэй оролцож, өөрийн санал бодлыг түүний шийдвэрт тусгах боломжийг олж авдаг/, орон нутгийн онцлогыг харгалзах /бодлого шийдвэр нь орон нутгийн бодит хэрэгцээ, шаардлагатай уялддаг, эл хэрэгцээ шаардлагыг нутгийн иргэдээс өөр хэнч мэдэхгүй/, төр иргэний харилцаа бэхжих /төрийн бодлого шийдвэрт иргэд ойртож, илүү мэдээлэлтэй байж чадна/, иргэдийн хяналт, хувийн санаачлага дээшлэх /иргэд өөрсдийн байгуулсан байгуулагаас өөрсдөө оролцож гаргасан шийдвэрийг хянах боломж илүү/, сонирхлын бүлгүүдийн оролцоо дээшилж, зөвшилцлийн механизм сайн ажиллана зэрэг үр дүнгээр илэрдэг. /2,4 болон цахим эх сурвалж 2. *Bundesministerium für wirtschaftliche Zusammenarbeit und Entwicklung Recht – Demokratie – Frieden Politik für Entwicklung*/

Нутгийн өөрөө удирдах ёсны зарчмууд бол орон нутгийн чанартай бүх асуудлыг бие даан шийдвэрлэдэг байх, нутгийн өөрөө удирдах байгууллага нь зохион байгуулалт, удирдлагын хувьд төрийн удирдлагын тогтолцооноос ангид байх, нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх хэлбэр нь зохион байгуулалтын хувьд олон янз байх, өмч, санхүүгийн хувьд боломжийн бүрэн эрхтэй байх зэрэг юм. /4/

Нутгийн өөрөө удирдах байгууллагын үндсэн чиг үүргийн нэг нь орон нутгийн хэргийг шийдвэрлэхэд иргэдийн оролцоог хангаж өгөх явдал мөн. Нутгийн өөрөө удирдах ёсны нэг үндсэн баталгаа нь нийгэм болон хувь хүний үйл ажиллагааны идэвхи, эрмэлзэл болж байдаг. /4/

Орон нутаг өөрийгөө удирдахын учир холбогдол нь ардчиллын үнэт зүйлс хөгжих болно. Ардчиллын үнэт зүйлс нь засаглал нутгийн иргэдийн хэрэгцээг ойлгож, тодорхойлох чадвар нэмэгдэх, нөгөө талаар хүмүүс хэн шийдвэр гаргаж буйг мэдэх учир хариуцлага нэмэгдэх зэргээр тайлбарлагдана. Шийдвэр гаргах үйл явцад ойр байгаа тул иргэдийн оролцох боломж илүү дээшлэнэ. /5/

Иргэдийн оролцоо хангагдсанаар орон нутгийн түвшин дэх бодлого сайжирна, засаглалд итгэх итгэл нэмэгдэнэ, ардчилал улам бэхжинэ. Бодлогыг үр дүнтэй хийгээд, хууль ёсны /легитим-хүлээн зөвшөөрөгдөж дэмжигдсэн/ байлгах шаардлагыг төр, засгийн газруудад улам бүр хүчтэй тавьж байна. Үүний тулд төр а/ илүү нээлттэй ил тод байдлыг бий болгох, шинээр хэрэгжүүлэх болон хэрэгжиж буй хууль, дүрмийн талаар иргэдэд мэдээлснээр тэд илүү ойлголттой болж, эргээд тавих хяналт сайжирна. б/ төр иргэдийн санал бодлоо хэлэх хэрэгцээг хангаж өгөхөөр чармайх болно. Бодлого боловсруулахад сонирхогч талуудын оролцох боломжийг төр олгож өгснөөр өөрийнх нь шийдвэрийг албадлагаар бус сайн дураараа биелүүлэх нөхцлийг бий болгоно. в/ олон нийтийн дэмжлэг буурахаас

сэргийлэх – төрийн бодлого шийдвэрт итгэх итгэл буурч, сонгуульд оролцохгүй байх, улс төрөөс хүнийсэх зэрэг үед идэвхитэй оролцоо нь нааштай өөрчлөлт гарах үндэс гэдгийг ардчилсан нийгэм иргэддээ ойлгуулдаг. /9/

Нутгийн өөрөө удирдах ёсыг жинхэнэ утгаар нь хөгжүүлснээр хүний эрх чөлөөтэй, нийгэмд идэвхитэй оролцон амьдрах гэсэн төрөлх мэдрэмжийг нь бадрааж өгнө. Тухайн нутаг дэвсгэр дээр оршин суугаа хүн бүрт нутаг усаа, хот тосгоноо эх нутгаа гэж үзэх, хүй элгэний бусад хүмүүсийн салшгүй нэг хэсэг гэж үзэх үзэл төлөвшинө. Нутгийн түвшний бодлогод санаа тавихаар илэрнэ. /23-т буй Б.Чимид, *Орон нутгийн удирдлагын тухай Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал*/

НӨУБ нь төрийн ч биш, төрийн бус ч биш үндсэн хуулийн статус бүхий байгууллага мөн. Энэ нь 1/ төрийн чиг үүргийг бус харин иргэдийн өмнөөс өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлнэ. 2/ хуулиар төрөөс байгуулах бус иргэд өөрсдөө сонгож байгуулдаг, 3/ зөвхөн тухайн нэгжийн иргэдийн дотроос тэдгээрийг төлөөлсөн төлөөллөөс бүрдэнэ, 4/ бүрэн эрхийн хувьд ЗЗНД-ийн нэгжийн эрх барих эрхтэй. /23-т буй Я.Долгоржав. *Нутгийн өөрөө удирдах ёсны хөгжил, хандлага*/

Сүбсидиаритет нь бие хүний эрх чөлөөт байдал, нэр төрийг хүндэтгэн, хүлээн зөвшөөрөх, улмаар нийгмийн удирдлага, улс төрийн шийдвэр гаргах үйл явцад чөлөөтэй оролцох, өөрийн амьдралдаа эзэн байх бололцоо нөхцөлийг нээж өгдөгөөрөө иргэний ардчилсан нийгмийн үед нийгмийн удирдлагын хамгийн тулгуур зарчим болдог. Энэ зарчимын үүднээс нутаг өөрийгөө удирдах нь иргэн өөрт хамаатай асуудлаа өөрөө шийдэхэд хүргэж буй зүйл гэж тайлбарлагдана. Нутгийн өөрийн асуудлыг нийгэм булааж үл болно. /23-т буй Б.Баттүвшингийн *өгүүллээс*/

Орон нутгийн түвшин дэх бодлого нь тухайн бүс нутгийн иргэдийн эрэлт хэрэгцээ, нийгэм эдийн засгийн хөгжил, иргэдийн аж ахуй эрхлэх онцлог, иргэдийн уламжлал, ёс заншлын онцлог, байгаль цаг уурын нөхцөл зэргийг нөхцөлдүүлэх учиртай. Орон нутгийн бодлого боловсруулах явцад НӨУБ-ын эрх хэмжээ тодорхой бус, иргэдийн оролцоо хангалтгүй, орон нутагт бодлого боловсруулах, сонголт хийх бодит боломж үгүй, төвийн олон бодлого, хөтөлбөрүүд нь орон нутгийн бодлогын санаачлагыг хүлдэг, орон нутгийн бодлого хэт ерөнхий асуудлаар хөөцөлдөх зэрэг сөрөг зүйлс байна. /24 –т буй П.Доржсүрэн *нарын судалгааны өгүүллээс*/

Улс орнуудад бий болсон ядуурал, ажилгүйдэл, авилгал гэх зэрэг үзэгдлүүдийг даван туулахын тулд захиргааны шинэчлэлийн асуудал тун чухал байна. Энэхүү ойлголт нь иргэний нийгмийн үеийн нийтийн захиргааны институт болох нутгийн өөрийн удирдах байгууллагын үйл ажиллагааг шинэчлэх асуудал юм. Захиргааны шинэчлэлийн үр дүнд ардчилсан эрхзүйт төр /demokratische Rechtsstaat/, хөгжилд баримжаалсан улс /entwicklungsorientierte und aktivierende Staat/, үйлчилгээ болон хэрэглэгчид чиглэсэн засаглал /leistungsfdhige und kundenorientierte Staat/ оршин тогтнох болно. Захиргааны шинэчлэлийн хамгийн гол үр дүн бол иргэдийн, игэний нийгмийн идэвхи санаачлагыг дэмжих, чадваржуулах, оролцоог дээшлүүлэх замаар

үр ашигтай, үр нөлөөтэй үйлчилгээг бий болгох явдал мөн. /цахим сурвалж 1. *Verwaltungsreform in der deutschen Entwicklungszusammenarbeit* /

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ТӨРӨЛ, ХЭЛБЭР, ТҮВШИН

Иргэдийн оролцоог дараах гурван түвшинд авч үздэг. **Мэдээлэл**- төр бодлого боловсруулахдаа мэдээллийг өөрийн санаачлагаар түгээдэг буюу иргэд эрэлт шаардлагынхаа дагуу тэрхүү мэдээллийг хүлээн авдаг. Ихэнхидээ мэдээлэл нь ганц урсгалтай зам байх ба төрөөс иргэд рүү чиглэдэг. **Зөвлөгөөн**-төр бодлого боловсруулах асуудлаараа иргэдийн хариу үйлдлийг хүсч байдгаас гадна түүнийг хүлээн авч байдаг. Бодлого боловсруулах явцад тэрхүү хариу үйлдлийг хүлээн авахын ямар асуудлаар хэний санаа бодлыг авахаа урьдчилан тодорхойлдог. Иргэдийн хариу үйлдлийг хүлээн авахын тулд тэднийг мэдээллээр хангах шаардлага төрийн өмнө үүсдэг. Төр иргэдийн хооронд ийм хязгаарлагдмал маягийн хос урсгалтай харилцаанаас зөвлөгөөн бий болдог. **Идэвхитэй оролцоо**-бодлого боловсруулах явцад иргэд идэвхитэй оролцдог. Энэ нь бодлого боловсруулах зорилгоор санал солилцоход иргэдийн оруулах хувь нэмэр юм. Харин бодлогоо томъёолох, эцсийн шийдвэр гаргах эрхийг төр өөрөө эдэлдэг. Бодлого боловсруулах явцад иргэдийг ороцуулна гэдэг бол түншлэлийн зарчимд тулгуурласан төр иргэдийн хос урсгалтай харилцааны хөгжиж гүнзгийрсэн хэлбэр юм. Хамтарсан ажлын хэсэг байгуулах, цуглаан, хэлэлцүүлэг, форум зохион байгуулах гэх мэт хэлбэрийг хэлж болно. /29,9/

	Хуулиуд	Бодлого	Институц	Хэрэгсэл	Хэрэгсэл /МТ/
Мэдээлэл /information/	Мэдээллийн эрх чөлөөний хууль	Цэнэглэх	Мэдээллийн төв	Бүртгэл, товхимол,	Албан ёсны хэвлэл, вэб
Зөвлөгөөн /consultation/	Зохицуулалтын үр нөлөөг үнэлэх	Цөөнхийн бүлгүүд	Зөвлөгчид	Иргэдээс санал авах ажил, нийтийн санал асуулга	И-мэйл
Идэвхитэй оролцоо /active participation /	Нийтийн хуулийн санаачлага	Хамтран ажиллах	Бодлогын төв нэгжүүд	Иргэний зөвлөл, хамтарсан ажлын хэсэг, хэлэлцүүлэг, форум	Цахим хэлэлцүүлгийн бүлэг /EDG/


Эх сурвалж Open Government. Fostering dialogue with civil society. OECD. 2003.

Орон нутгийн хэргийг шийдвэрлэхэд оролцох иргэдийн оролцоо нь бүх нийтийн санал асуулга, сонгууль зэрэг хүсэл сонирхлыг шууд илэрхийлэх, нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд идэвхитэй оролцох гэсэн хоёр төрөл байна. Хэлэлцэх асуудал, шийдвэрийн төслийг сайтар боловсруулахын тулд ажлын хэсэг байгуулж ажиллуулах, судалгаа хийх, үзлэг шалгалт явуулах, иргэдийн санал хүсэлтийг сонсох, санал асуулга явуулах зэрэг арга хэлбэрүүдийг сонгох хэрэгтэй./4/

Орон нутаг дахь иргэний нийгэм нь нутгийн удирдлагаас харьцангуй бие даасан байдалтай байж, өөрсдийн болон нутгийн иргэдийн эрх ашгийг илэрхийлэх, дэвшүүлэн тавих үүрэгтэй тул орон нутагт ардчилал хөгжих, нягтрах, жирийн иргэдийн сонирхол дээш уламжлагдах чухал механизм болдог./16/

Улс төрийн оролооны үндсэн хэлбэрүүд нь орон нутгийн сонгуульд санал өгөх ба нэрээ дэвшүүлэх, бүх ард түмний санал асуулга, төрийн албан хаагч, байгууллагад хандах, үндсэн хуулийн цэцэд хандах, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хандах, хурал цуглаанд оролцох, эвсэл бүлэг байгуулах гэх мэт хэлбэрүүдтэй байна. /25/

Бодлого нь нутаг дэвсгэрийн олон нийтийн амьдралаас урган гарсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэдэг бөгөөд үнэн хэрэгтээ түүнийг шийдвэрлэх хүртлэх маш олон үйл явцыг дамждаг. Эдгээр нь 1/ олон нийтэд тулгарсан асуудлыг тодорхойлох, 2/ бодлогын хувилбаруудыг гаргах, томъёолох, 3/ сайн буюу илүү үр дүнтэй гэж үзсэн бодлогын шийдлийг сонгох, 4/ бодлогыг төлөвлөх, 5/ хэрэгжүүлэх ба хяналт тавих, 6/ эцэст нь түнд үнэлгээ хийх гэсэн 6 үе шатаас тогтоно. Үүнийг бодлогын орчил гэх бөгөөд иргэдийн бодлогын түвшин дэх оролцоог 6 мөчлөгөөр тусгайлан авч үзэж болох юм./30, 29/



ОРОН НУТГИЙН ТҮВШНИЙ БОДЛОГОД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭЭШЛҮҮЛЭХ, НӨУБ-ЫН ИНСТИТУТЧИЛЛЫГ ХАНГАХ АРГА ЗАМУУД

Шведийн коммуны удирдах байгууллагууд нь зохион байгуулалтын 3 загварыг ашигладаг. *Салбарчилсан загвар*-уламжлалт загвар ба төлөөлөгчид тодорхой салбарыг хариуцсан салбаруудад хуваан ажиллах явдал юм. *Газар нутгийн загвар* – энэ загварын үүднээс хороод нь хязгаарлагдмал орон зайд үйл ажиллагаа явуулах үүрэг бүхий газар нутгуудад хуваагдан ажиллах зарчим юм. Энэхүү төвлөрлийг сааруулах загвараар доод нэгжийн болон хөршийн холбоо гэх мэт бүтцийг ашигладаг. /манайх дээр бол баг, хорооны бүтэц, хөршийн холбоог ашиглах/ *Үйл ажиллагааны загвар*- захиалагч болон гүйцэтгэгч гэх загвар ба хороо нь коммуны

захиргааны байгууллага болон бусад байгууллагуудад нутгийн өмнөөс захиалга өгч гүйцэтгүүлдэг. /5/

Германы нутгийн удирдлагын байгууллага нь газарзүйн хувьд хаана байрлаж байгаа, аль муж улсад харъяалагдах зэргээсээ хамааран дотоод зохион байгуулалт, бүтцийн хувьд ялгаатай. Гэвч иргэдийн оролцоог хангах чиглэлээр нийтлэг арга зам, механизмуудыг хэрэглэдэг. Үүнийг байгууллагын дотоод бүтэц, зохион байгуулалт, хурлын үйл ажиллагааны технологи, нутгийн удирдлагын шаардлагаар бий болсон үүсмэл бүтэц гэсэн гурван чиглэлээр авч үзэж болно. *Нэгдүгээрт* нутгийн удирдлагын байгууллага нь дотооддоо орон нутгийн хөгжлийн асуудлуудаар дагнасан албан ёсны дэд зөвлөлүүдийг байгуулан ажилладаг. Үүнд нийгмийн дэг журам болон эрхзүйн, нийгмийн тусламж, дэмжлэгийн, боловсролын, байрилга, байгууламжийн, экологийн, эдийн засаг, санхүүгийн гэсэн нийтлэг бүтэц бий болж, тус тусын хүрээндээ бүтээлчээр ажиллах, /бодлогын төсөл боловсруулах, олон нийтийг зохион байгуулах г.м/ эргээд өөрийн удирдлагын байгууллагын бүтцэд тодорхой хууль ёсны чиг үүрэг, эрх хэмжээгээр холбогддог. *Хоёрдугаарт* хурлын үйл ажиллагааны явцад иргэдийн санал, хүсэлтийг тусгайлсан журмын дагуу авдаг. Энд иргэн хувь хүн, бүлэг, байгууллага саналаа өгөх боломжийг хангах ёстой. *Гуравдугаарт* нутгийн удирдлагын дэргэд төр, иргэний нийгэм, хувийн хэвшил хамтарсан зөвлөлүүд бий болдог. Энэ нь саналуудыг нэгтгэх, бодлого боловсруулах, шийдэл гаргахад анхаардаг. Жишээ нь залуучуудын нийгмийн тусламжийн асуудлаар хөтөлбөр боловсруулахад нийгмийн бодлогын зөвлөл ажиллах ба үүнд нутгийн удирдлагаас, ТББ-аас, сүм хийдээс гэхчлэн суудлын тоог нутгийн удирдлага өөрөө журмаар батлан гаргасан байдаг. /цахим эх сурвалж 3, 4/

Шведийн коммуны удирдах байгууллага иргэдийн оролцоог хангах үүднээс хурлыг төвд бус тосгон, нэгж дээр зохион байгуулах, улс төрчдийн дэвшүүлсэн асуудлаар нээлттэй форум хийх, “нөгөө талаас хийх мэтгэлцээн¹” явуулах, зөвхөн коммуны хуралдаан ч бус түүний хорооны хуралдааныг иргэдэд ил болгох, хуралдаан эхлэхээс 7 хоногийн өмнө хэлэлцэх асуудал, бүх баримт бичгийг бүх номын сан, иргэдийн төвд тараах, зөвлөлийн хуралдааныг ТВ-ээр цацаж, цаг үеийн асуудлын мэтгэлцээнийг харуулсан бичлэгийг номын санд байршуулах, хурлыг дундаа завсарлагаатай хоёр хэсэгт хувааж хийх, завсарт нь улс төрчид иргэд хамтран зөвлөлийн үйл ажиллагааг танилцуулах өдөрлөг, коммуны үзэсгэлэн гаргах зэрэг арга замуудыг сонгодог байна. /5/

Иргэдийн оролцооны хүрээнд ихээхэн чухал зүйл бол мэдээллийн нээлттэй болон чөлөөт байдлыг хамгаалах загвар юм. Нутгийн өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг /коммунд ирж буй, коммунаас илгээж буй захидал, э-мэйл, хэвлэл мэдээлэл, коммуны хурлын шийдвэр, протокол/ таван чиглэлийн холбогдох байгуулагад нь илгээх ба бүгдийг хэвлэж архивт хадгална. /5/

¹ Энэ нь тодорхой асуудлаар иргэний төлөөлөл дотроо орон нутгийн тулгамдсан асуудлаар мэтгэлцээн явуулах ба улс төрчид зөвхөн асуулт тавьдаг.

Иргэдийн оролцоог хангах үүднээс дараах гурван чиглэлээр бодлогын сонголтуудыг ашиглах явдал гадаадын орнуудад байгаа нь харагдаж байна. /9/

		Мэдээлэл
1	Ерөнхий элементүүд	Иргэдийн хүртэж болох мэдээллийг тодорхойлох /хүртэж болохгүй мэдээлэл хувь хүний нууц, аюулгүй байдлаар хязгаарлагддаг/ Мэдээллийн олдоц, хүлээн авах арга замыг тодорхойлох нь Иргэнээс мэдээллийг хүссэн учир шалтгаанаа тайлбарлахыг төр шаардахгүй байх Төрийн албан хаагч татгалзсан шалтгаанаа бичгээр тайлбарлах ба харин түүнийг иргэн давж заалдах талаар хуульчилах Иргэд онцлон шаардаагүй ч гэсэн гол мэдээллүүдийг төр зайлшгүй нийтэлж байх үүргийг хуульчилах Мэдээллийг ямар хугацаанд багтааж хүргэхийг заах
2	Бодлогын элементүүд	Хуульд зааснаас богино хугацаанд хариу өгч байхыг бодлогоор даалгах Мэдээллийн аль ч чиглэлд эсвэл эсвэл үндсэн эрхээ хэрэгжүүлэх гэж байгаа үед үнэ төлбөргүй өгөх Мэдээллийг шуурхай хэвлэн нийтлэх Мэдээллийг хүлээн авах хийгээд түгээх ажлыг зохих үр дүнтэй явуулахын тулд төр мэдээллийг олон нийтэд сайтар ойлгуулах Мэдээллийг товч тодорхой, бүрэн гүйцэд байлгах үүднээс олон нийтэд хандсан материалыг бэлтгэхэд баримтлах заавар, үндсэн чиглэл хуульчлах Иргэдтэй мэргэжлийн болон нэр төртэй харилцаа тогтооход чиглэсэн стандарт, жишгийг хуульчилж өгдөг. Тусархаг, шуурхай, найрсаг харьцах
3	Зохион байгуулалт	Төр, засгийн газрын бүх шатны байгууллагын хэвлэл мэдээллийн алба мэдээлэл түгээх ажлыг гүйцэтгэх Зохицуулалтын үүргийг зөвлөл байгуулагдан хийж болох Мэдээллийг түгээхдээ мэдээллийн болон хувь хүний нууцыг хамгаалахад бие даасн байгууллага чухал ба иргэдээс ирсэн гомдол дээр хяналт тавих

		Зөвлөгөөн
1	Ерөнхий элементүүд	Санал асуулгад сонгуулийн насны бүх иргэд оролцох эрхтэй Иргэдээс өргөх бичиг барих эрхтэй байх Шийдвэр гаргахын өмнө хэлэлцүүлэг явуулах ба шийдвэр хэрэгжиж эхлэхээс өмнө гомдол гаргаж эрхийг хуулинд тусгах Хууль, бодлого шийдвэр ашиг сонирхлыг нь хөндсөн тохиолдолд өвөрмөц бүлгүүдтэй зөвлөлддөг байх талаар хуулинд тусгах
2	Бодлогын элементүүд	Төр, удирдлагын байгууллагыг иргэд болон сонирхогч талуудтай зөвлөлдөж байхыг шаардахыг бодлогоор зохицуулах, мөн зөвлөгөөн цаг үеэ олсон, гүн гүнзгий, аливаа асуудлыг нарийвчлан хэлэлцэхүйц байхыг тусгах Зөвлөгөөний тухай дүрэм байж болох бөгөөд олон нийтийн мэдэгдэл, факс, захидал, олон нийтийн хэлэлцүүлэг гэхчлэн түүний хэлбэрүүдийг зааж өгөх Иргэдийн хариу нүдэнд харагдахуйц, хүртээмжтэй, хариуцлагатай гэсэн гурван шалгуурыг зааж өгөх
3	Зохион байгуулалт	Бодлогын асуудлаар иргэд, ИНБ-аас илэн далангүй мэдээлэл авахад урт болон богино хугацааны оролцогч талуудаас тогтох зөвлөлдөх зөвлөлүүдийг байгуулах Иргэдэд төрийн байгууллага болон захиргааны талаар зөвлөгөө өгдөг төвүүд, харилцах утсыг ажиллуулах /санал гомдлоо хэрхэн гаргах талаар/ Удирдах байгууллагын хороод хууль, дүрэм сурталчлах, иргэдийн хариу үйлдлийг хөхүүлэн дэмжих ажлыг явуулах Иргэдийн зөвлөгөөн хэр явагдаж байгааг омбудсмен хянах ингэхдээ иргэдийн саналаар юмуу өөрсдийн санаачлагаар ханалт тавих.

		Идэвхитэй оролцоо
1	Ерөнхий элементүүд	Бодлого боловсруулах, бодлогын хувилбар санал болгоход иргэд бие даасан чадвартай гэдгийг хүлээн зөвшөөрөх Иргэд бодлогын түвшинд өсөн нэмэгдэж байгаа өөрсдийн оролцоонд дүйхүйц өндөр хариуцлагатай байх Идэвхитэй оролцоо нь төр иргэн хоёрын харилцааны хамгийн шинэлэг талбар мөн гэдгийг ойлгох
	Бодлогын элементүүд	Иргэдэд хууль, шийдвэрийн болон заавал дагаж мөрөх албагүй санал асуулгыг санаачлах эрх олгох /заавал дагаж мөрдөх санал асуулгыг санаачлах эрхийг олговол төлөөллийн ардчиллын үйл ажиллагаанд шууд ардчиллын элементийг хүчтэй болгодог/ Идэвхитэй оролцоог бий болгох, түүний нөхцлийг дэмжих үүднээс төрөөс бодлого гаргах Иргэдтэй ажиллах заавар гаргах, иргэдэд оролцооны талын арга техник, мэдлэгийг ойлгох, сайн практикыг

Дотоодын эх сурвалжуудаас үзэхэд орон нутгийн түвшинд бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явц дах иргэдийн оролцоог дээшлүүлэх арга замын асуудлыг бодлого төрөн гарч, хэрэгжиж дуусах хүртэлх үндсэн мөчлөгүүдээр нь авч үзэх хэрэгтэй мэт санагдаж байна. Ингэхдээ нэгдүгээрт бодлогын асуудлыг дэвшүүлэн гаргаж ирэх, хоёрдугаарт бодлогын хувилбар боловсруулах, бодлогын шийдэл сонгох, гуравдугаарт шийдвэр гаргах, дөрөвдүгээрт хэрэгжүүлэх гэсэн үндсэн гурван мөчлөгт иргэдийн оролцоог дээшлүүлэх талаар материалуудад хэрхэн хөндсөнийг утга санаа давхардуулалгүй дараах байдлаар хураангуйлан авч үзэв. /4,6,7, 13, 14,24/

Бодлогын асуудал дэвшүүлэх үе шат

- Хэлэлцэх асуудлыг оновчтой сонгоход анхаарах
- Хуралдаанаар хэлэлцсэн асуудлын олон жилийн судалгаатай болох
- Иргэдийн дунд хурлаар хэлэлцэн, шийдвэрлэх асуудлаар судалгаа явуулах
- Орон нутгийн бодлогын асуудлаар оролцогч талуудын зөвлөгөөн, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах
- Хурлаар хэлэлцэх асуудлаа урьдчилан хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд танилцуулах, нээлттэй нэвтрүүлгээр ярилцлага явуулах
- Хурал хэлэлцэх асуудлаараа мэргэжлийн хүмүүсээр баг байгуулж, тэдний саналыг сонсдог байх
- Иргэдийн саналыг амаар, бичгээр, хайрцгаар тогтмол авдаг байх
- Иргэд төлөөлөгчтэй уулзах танхи ажиллуулах /төлөөлөгчийн нэрс, цагийн хуваарийг тодорхой тусгах/

Бодлогын хувилбар боловсруулах, сонгох

- хурлаар хэлэлцэх асуудлыг тал бүрээс нь шүүн хэлэлцэхийн тулд төлөөлөгч нарын сургалт явуулах
- хурлын хуралдаанд бэлтгэх ажлын төлөвлөгөө гарган ажиллах, төлөвлөгөөнд хэрэгжүүлэх ажлыг нэг бүрчлэн нарийвчлан тусгах, хэлэлцэх асуудал дэвшүүлэх болон гаргах шийдвэрийн төслийн боловсруулалтад онцгой анхаарах
- ИТХ-ын дэргэд “Иргэний нийгмийн байгууллагын сүлжээ” байгуулж ажиллах
- Орон нутгийн бодлогын асуудлаар оролцогч талуудын зөвлөгөөн, хэлэлцүүлэг хийх
- Хурал хэлэлцэх асуудлаараа мэргэжлийн хүмүүсээр баг байгуулж, тэдний саналыг сонсдог байх

Бодлогын шийдвэр гаргах

- Хурлын дэгийг боловсронгуй болгох, загвар боловсруулан баталж мөрдүүлэх /УИХ, ЗХЭГ, УИХ-ын нутгийн удирдлагын дэд хорооноос ч байж болно/

- Хуралдааны жилд хийх тооны хязгаарыг нэмэгдүүлэх
- Иргэд ИТХ-ын хуралдаанд чөлөөтэй орж суух, санал бодлоо илэрхийлэх боломжийг олгох
- Хэн ямар асуудалд, ямар байр суурьтай байгаа нь мэдэх боломжгүй байдаг тул, хурлыг өргөтгөсөн хэлбэрээр явуулах /хамгийн тулгамдсан асуудлууд хэлэлцэх үед бол зайлшгүй/
- Санал хураалтыг /хувь хүний болон төрийн нууцаас бусад тохиолдолд/ ил болгох, нэрээр хураадаг болгох
- Хурлын тэмдэглэл, протоколтой танилцах боломжоор хангах

Бодлогын шийдвэрийг хэрэгжүүлэх

- Хурлын шийдвэрийн талаар сурталчлах ажлыг сайн зохион байгуулах
- Хурлын шийдвэрийн талаар мэдээллийн самбар ажиллуулах
- Иргэд хуралтай хариуцлага тооцож ажилладаг болох
- ИТХ-ын хуралдааныг орон нутгийн телевизээр нэвтрүүлэх
- “Төлөөлөгчдийн өдөрлөг”-өөр байгууллагуудын удирдага, шинжээчдийн мэдүүлгийг сонсож, төлөөлөгчдийн дүгнэлтийг сонсох
- Орон нутгийн хөгжилд иргэний нийгмийн байгууллагын оролцоо, хамтын ажиллагаа” сэдэвт сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг хийх
- Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчдийн тойрогтоо ажиллах, тайлан тавих, төр засгийн болон хурлынхаа бодлого шийдвэрийг тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх ажилд сонгогчдыг татан оролцуулах
- Төлөөлөгч сар, улирал бүр сонгогчиддоо ажлаа тайлагнадаг байх
- Хурлын шийдвэр, тэмдэглэл, протокол болон бусад материалыг номын санд байршуулах

Иргэдийн оролцоог хангах асуудал нь НӨУБ-ын үйл ажиллагааны институтчилалтай салшгүй холбоотой. Тиймээс эл байгууллагын бүтэц, зохион байгуулалт, төлөвшлийн асуудлаар өмнөх эх сурвалжуудад дэвшүүлсэн санал, зөвлөмж, дүгнэлтүүдийг доор авч үзлээ. /4,6,7, 13, 14, 24/

НӨУБ-ын институтжих хүрээнд

- Хурал өөрийн онцлогт тохирсон байнгын хороо, комисс хэлбэрийн байгууллага байгуулж, тэдгээрт төлөөлөгчдийг хувиарлан ажиллуулах, энэ байгууллагын ажиллах журам, бодлого боловсруулах, шийдвэр хэрэгжүүлэх хүрээний үүрэг, хариуцлагыг хуульчилж өгөх
- Тодорхой шаардлагаар буюу судлах шалгах, дүгнэлт гаргах зэрэг асуудлаар түр хороо, хэсгүүд байгуулан ажиллуулах, ажиллах журмыг нь тогтоох эрхийг ИТХ-ын тэргүүлэгчдэд олгох хэрэгтэй байна.
- Аймаг, сумын ИТХ-ын дэргэд нам бүлэг байгуулах эсэх, түүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг тодорхой болгох
- Төсвийн удирдлага, санхүүжилтийн хуулиас татгалзах
- Бүх шатны ИТХ-д гүйцэтгэх засаглалын албан хаагчид сонгогдох тооны хязгаарлалт тавих
- ИТХ-ын тэргүүлэгчийг ажлын үр дүнгээр нь урамшуулал олгох

- ИТХ-ын дэргэд олон нийттэй харилцах ажилтантай болгох
- Намын бүлэг хуралд асуудал дэвшүүлж болохгүй, учир нь сонгогдсоноор намын бус нийт иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлэх ёстой болж байна.
- ИТХ, тэргүүлэгчдээс орон нутагт удирдах боловсон хүчинг томилоход оролцох
- ИТХ, тэргүүлэгчдийн өөрийн баталсан төсвийн орлого, зарлагын байдалд тавих хяналтын механизмыг оновчтой болгох
- ИТХ өөрөө үндсэн хуулийн цэцэд ханддаг эрхтэй болох
- Хурлын хуралдааны тоог нэмэгдүүлэх
- Хурлын чиг үүрэг, эрх хэмжээний талаар иргэдэд сургалт явуулах
- Төлөөлөгчийн ажлын үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгож, мөрдүүлэх
- ИТХ-ын төсөвт сургалт, уулзалт, хэлэлцүүлэг, хэвлэл мэдээлэл, гарын авлага, сурталчилах зэрэг зардлуудыг суулгаж өгөх

НӨУБ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ИРГЭДИЙН ОРОЛЦООНД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛҮҮД

Төр, засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа бодлого шийдвэрийн практик үр дүн нь зарим тохиолдолд орон нутгийн удирдлагын удирдлагын төрийн захиргааны талыг хүчтэй болгох, улмаар төвлөрлийг түлхүү болгох чиглэлд илүү тусгалаа олж байна. Үүнийг орон нутгийн төсвийн бүтцэд тухайн орон нутгаас бүрдүүлж байгаа хэсэг, төрөөс олгож байгаа шилжүүлэг хоёрын харьцаанаас төдийгүй улсын төсвийн хөрөнгөөр хийгддэг үйлчилгээ, орон нутгийн төсвөөр хийгддэг үйлчилгээ хоёрын, Засгийн газар, засаг даргын шугмаар тавьдаг боловсон хүчин ба НӨУБ-аас мэдэж тавьдаг хүний нөөц хоёрын, төрийн хуулиар зохицуулагддаг арга хэмжээ болон НӨУБ-аас гаргасан дүрэм журмаар зохицуулагддаг харьцаа хоёрын зэрэг харьцаанаас харж болно. Энэ тохиолдолд иргэд нутгийн удирдлагад бус төрийн удирдлагад илүү ач холбогдол өгөх явдал бодитой байна./6,7/

Орон нутагт өөрийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааны институтчилал нийтлэг маш доогуур байна. Зарим эх сурвалжаас үзэхэд ИТХ-ын хурлын бэлтгэл үйл ажиллагаа хангалтгүй, иргэдээс бодлогод зориулан санал хүсэлт авах нь доогуур түвшинд байгаа ба доод шатны хурлын шийдвэр, тогтоолыг судлан хэлэлцэх, олон талаас харж бүтээлчээр бодлого боловсруулах туршлага дутмаг байна. Түүнчлэн ИТХ-ын төлөөлөгчид иргэдтэйгээ тулж ажиллах, тэдний дунд санал асуулга, хэлэлцүүлэг хийх, доод шатны хурлын шийдвэрийг судлах, улмаар өөрөө бодлого боловсруулах гэх мэт арга замуудыг ашиглан бүтээлч хандах нь үгүйлэгдэж байна. /7,8/

Өнөөдрийг хүртэл ИТХ нь засаг даргийн тайланг хэлэлцэж, төсвийг ёс төдий батлахаас өөр гавьтай зүйл хийж чадахгүйд хүрсэн нь үүний нийтлэг дүр зураг юм. Төвлөрөл саарах биш улам эрчимжсэн явдал нь НӨУБ-ын хөгжилд саад учруулсан гол хүчин зүйл хэвээрээ байна. /6.7.8, 10,11/

Судалгааны дүнгүүдээс үзэхэд иргэд нутгийн өөрийн удирдлагын байгууллагын эрх хэмжээ, чиг үүрэг, явуулж буй үйл ажиллагаа, гаргаж буй шийдвэрийн талаар мэдлэг муутай ба мэдээлэл хангалтгүй авч байгаа нь тэдний оролцоо доогуур байхад нөлөөлж байна. /10,11,12,13,14, 24/

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын үйл ажиллагааны материаллаг нөхцлийг бүрдүүлэх, эдийн засгийн баталгааг хангах ажил өнөө хир нь хуулийн ерөнхий тунхаглалаас хэтрээгүй байна. /1/ НӨУБ төсөв, мөнгөний хүрэлцээгүйгээс болоод иргэдийг бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл ажиллагаанд өргөнөөр оролцуулж чаддаггүй юм. Мөн байгууллагын хүрээнд албан ёсны ажлын орон тоо цөөн, төлөөлөгч, тэргүүлэгчид иргэд, олон нийтийн санал, бодлыг судлах, тэднийг зохион байгуулж ажиллахад төдийлөн хүртээмжтэй байж чадахгүй байна. /12,13,14/

Улс төрийн хүнийсэл бол хортой үр дагавартай төдийгүй, иргэд өөрсдийн амьдралд хамгийн их хамаатай, өөрийнх нь төлөө байх ёстой бодлого шийдвэрийг гаргах үйл явцаас хөндийрөн, өөртөө хамаагүй гэж үзэх байдлаар илэрдэг. Иргэдийн дунд орон нутгийн улс төрд ач холбогдол өгөхгүй, түүнээс хөндийрөх хандлага бодитой оршиж байна. /16,24/

Орон нутгийн түвшинд иргэний нийгмийн хөгжил дорой байгаа нь иргэд орон нутгийн түвшинд бодлого боловсруулах, шийдвэр гаргах үйл явцад нөлөөлөх энэхүү механизмыг ажиллах боломжгүйд хүргэж байна. /10, 17/

Орон нутгийн ИТХ зөвхөн улс төрийн асуудалд анхаарлаа хандуулж, түүнээс болж жирийн ард иргэдийн тулгамдаж байгаа нийгэм, эдийн засгийн асуудлыг цогц байдлаар шийдэхэд саад болж байна. /7/

Монголчуудын сэтгэлгээний өвөрмөц төрх, менталитет нь нэгдсэн хатуу гарт захирагдах, төвлөрсөн эрх мэдлийн харьяанд байх улс төрийн үнэт зүйлсийг бүрэлдүүлж ирсэн байна. Тиймээс энэ чанар нь иргэд орон нутгийн түвшинд асуудлаа шийдүүлэх, бодлогод нөлөөлөх боломжтой гэж үзэхээсээ илүү төвөөс хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрт илүү анхаардаг болох нь харагддаг. /22/

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ ЭРХЗҮЙН ЕРӨНХИЙ ОРЧИН

Монголчууд шинэ үндсэн хуулинаа иргэд засаглалын үйл хэрэгт оролцох эрхзүйн ерөнхий үндэслэлүүдийг тунхагласан бөгөөд цаашилбал орон нутгийн түвшин дэх иргэдийн оролцоо нь нутаг дэвсгэрийн нэгж, түүний оршин тогтнох эрхзүйн орчныг бүрдүүлсэн хэд хэдэн хууль тогтоомжуудад тусгагдсан байна. Өөрөөр хэлбэл өөрчлөлт шинэчлэлтээс хойш иргэд өөрсдийн оршин амьдарч буй орон нутгийнхаа удирдлагын үйл хэрэгт оролцох эрхзүйн орчныг бүрдүүлсэн хэд хэдэн хууль, эрхийн актуудыг хууль тогтоох байгууллагаас батлан гаргажээ. Тухайлбал “Засаг, захиргаа, нутаг дэвсгэийн нэгж түүний удирдлагын тухай хууль”/1992/, “Хот тосгоны эрхзүйн байдлын тухай хууль”/1994/, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль”/1995/ болон бусад хууль тогтоомжуудыг дурдаж болох байна.

Монгол улсын үндсэн хууль

	Заалтууд
1	Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим юм. 1-р бүлгийн 1-р зүйлийн 1-р хэсэг
2	Монгол улсад засгийн бүх эрх ард түмний гарт байна. 1-р бүлгийн 3-р зүйлийн 1
3	Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.
4	Иргэд шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. 2-р бүлгийн 16-р зүйлийн 9
5	Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. 2-р бүлгийн 16-р зүйлийн 10
6	Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй. 2-р бүлгийн 16-р зүйлийн 12
7	Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөтэй. 2-р бүлгийн 16-р зүйлийн 16
8	Монгол усын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ. 4-р бүлгийн 59-р зүйлийн 1
9	Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. 62-р зүйлийн 2

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

	Заалтууд
1	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх үндсэн зарчим баримтлана. 2-р бүлэг. 8-р зүйл
2	Хурал нь дээд шатныхаа Хурал, байгууллагын эрх хэмжээнд хамаарахаас бусад нутаг дэвсгэрийн амьдралын ямар ч асуудал хэлэлцэн шийдвэрлэж болно. 3-р бүлэг. 11-р зүйлийн 1
3	Хурлын тэргүүлэгчид хурлын чөлөө цагт түүний онцгой эрхэд хамруулснаас бусад бүрэн эрх эдлэх бөгөөд дараах бүрэн эрхийг өөрөө бие даан эдэлнэ: 11-р зүйлийн 2 1/ хурлын хуралдааныг товлон зарлах, түүний бэлтгэл хангах, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон санал, шийдвэр боловсруулах 3/ иргэн, аж ахуйн нэгж, төр, олон нийтийн байгууллагаас тавьсан санал, өргөдөл, гомдол шийдвэрлэх 5/ эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн төсөл, төр, нийгмийн амьдралын чухал асуудал ард нийтээр хэлэлцүүлэх ажлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах 6/ шаардлагатай гэж үзвэл нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын асуудал хэлэлцэж шийдвэрлэх
4	Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга дараах бүрэн эрх эдэлнэ. 12-р зүйлийн 1 3/ хурлын тэргүүлэгчид бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх 4/ хурал, түүний тэргүүлэгчдээр хэлэлцүүлэх асуудлыг хүлээн авах, тэдгээрийг боловсруулах, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах 14/ харьяа нутаг дэвсгэр дэх нам, олон нийт, шашны байгууллагуудтай харилцах 15/ иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тавьсан санал, өргөдөл, гомдлыг барагдуулах ажлыг зохион байгуулах 16/ сум дүүргийн Хурлын байгууллагад мэргэжил, аргагүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах
5	4-р бүлэг. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн үйл ажиллагааны зохион байгуулалт

	<p>Хуралдаан /23-р зүйл/ 1/ Хурлын үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан мөн. 2/ Аймаг, нийслэл, сум дүүргийн Хурлын ээлжит хуралдааныг жилд нэг удаа хийнэ. 3/ Хурлын анхдугаар хуралдааныг сонгууль болсноос хойш 20 хоногийн дотор өмнөх хурлын тэргүүлэгч, бусад хурлыг хурлын тэргүүлэгч зарлан хуралдуулна. 4/ Хурлын анхдугаар хуралдаанаар аймаг, нийслэлийн хурлын тэргүүлэгчдийг дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан 7-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр хурлын төлөөлөгчдийн дотроос дөрвөн жилийн хугацаагаар сонгоно. Сум дүүргийн хурлын тэргүүлэгчдийг даргыг оролцуулан 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр дараагийн хурлын Тэргүүлэгчдийг сонгох хүртэл хугацаагаар анхдугаар хурлаас сонгоно. Аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдийн дарга, аймаг, нийслэлийн ИТХТ-ийн нарийн бичгийн дарга орон тооны байна.</p> <p>24-р зүйл Хуралд асуудал оруулах эрх 1/ Хурлын төлөөлөгч, тэргүүлэгчид, тухайн нэгжийн засаг дарга Хуралд хэлэлцүүлэхээр асуудал санаачлан оруулах эрхтэй. 2/ Төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж тухайн шатны Хуралд, сум, дүүрэг, баг хорооны Хурал зохих дээд шатны Хуралд асуудал хэлэлцүүлэхээр санал дэвшүүлж болно.</p> <p>25-р зүйл Хурлын тогтоол 1/ Хурал хэлэлцсэн асуудлаараа тогтоол гаргана. Тогтоолыг тухайн хурлын хуралдаанд оролцсон нийт төлөөлөгчдийн олонхийн саналаар батална.</p> <p>26-р зүйл Аймаг, нийслэлийн хурлын төлөөлөгчийн бүрэн эрх 2/ хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах 4/ хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл сонсох, сонсгол хэлэлцүүлэх санал гаргах 5/хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд тайлбралан таниулах</p> <p>27-р зүйл Сум дүүргийн Хурлын төлөөлөгчийн бүрэн эрх 26-р зүйлийн 4-т зааснаас бусад эрхийг эдлэнэ</p>
6	<p>5-р бүлэг. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааны баталгаа Хурал, засаг даргаас эрх хэмжээнийхээ дотор хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр байх бөгөөд түүнийг байгууллага, албан тушаалтан, иргэд заавал биелүүлнэ. 32-р зүйлийн 1 Хурал, засаг даргын зохион байгуулсан, зөвшөөрөл олгосон хурал, жагсаал, цуглаан, санал асуулга хуульд нийцсэн байвал зохино. 33-р зүйлийн 1</p>

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хууль

	<p>4-р зүйл. Хуулийн нэр томъёо 1/ “Өргөдөл” гэж энэ хуулийн 4-дүгээр зүйлийн 4-т зааснаас бусад асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан хүсэлтийг, өргөдөл нь санал, мэдэгдлийн шинжтэй байж болно. 2/ “Санал” гэж төрийн ба нутгийн удирдлагын байгууллага, албан тушаалтны</p>	

- Өнөөгийн эрхзүйн орчны хүрээнд ИТХ-ын бодлого тодорхойлох статусын шинжүүд**
- Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг , баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэнэ.
 - Хурлын шийдвэрийг Засаг дарга, түүний тамгын газар хэрэгжүүлэх үүрэгтэй.
 - ИТХ нь хуульд заасан эрх, үүргийнхээ дагуу төрийн байгууллага, албан тушаалтанд үүрэг даалгавар өгөх эрхтэй.
 - Төрийн байгууллагын төсөв, зардлыг батлах эрхтэй.
 - Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлөх огцруулах тухай санал тавих эрхтэй.
 - Өөрийн гаргасан шийдвэр, төр засгийн хууль тогтоомж, шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэрийн төр захиргаа, аж ахуйн байгууллагын хүрээнд хянаж шалгах эрхтэй.

Эх сурвалж: Монгол улсад нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь. Сургалтын гарын авлага. УБ 2003 он

ИТХурлын шийдвэр эрхийн актын хэлбэрээр гарна.

Хурлын шийдвэр ИТХ-ын тогтоол, ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, эдгээр тогтоолоор баталсан журам, дүрэм, заавар, төлөвлөгөө, бусад эрхийн актын хэлбэрээр гарна.

Акт – Аливаа үйл ажиллагаа, үйл явдал, бодит байдлын үнэн зөвийг шалгаж, нотолгоо, дүгнэлт гаргаж, хууль тогтоомжийн дагуу үйлдсэн баримт бичиг мөн.

Шийдвэр – Хэд хэдэн байгууллага хамтран боловсруулсан буюу тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан баталж мөрдүүлсэн баримт бичиг

Тогтоол – Асуудлыг хамтран хэлэлцэж баталсан баримт бичиг

Зөвлөмж – Удирдлагын аливаа үйл ажиллагааг сайжруулах болон удирдлагын шийдвэрт тусгуулах санал, үзэл баримтлалыг хураангуйлан нэгтгэсэн баримт бичиг

Дүрэм – Байгууллагын үйл ажиллагааны зарчим, эрх үүрэг, зохион байгуулалтын бүтэц, бусад байгууллагатай харилцах зарчмыг тодрхойлсон баримт бичиг

Журам – Тодорхой үйл ажиллагаанд баримтлах дэг, горимыг тогтоосон баримт бичиг

Заавар – Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалт, дэс дарааллыг нарийвчлан заасан баримт бичиг

Төлөвлөгөө - Хийж гүйцэтгэх ажил, арга хэмжээ, үүрэг хариуцлагыг хуваарилж, гүйцэтгэх ажлын дэс дараалал, хугацаа, хариуцагч, гүйцэтгэгчийг тогтоосон баримт бичиг

Эх сурвалж: Стандартчилал хэмжилзүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2002 оны 4-р сарын 25 ны өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан Баримт бичгийн нэр төрөл.

Ашигласан ном зохиолын жагсаалт

1. Бяраагийн Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал : Нутгийн удирдлага. Гуравдугаар дэвтэр. 2004 он
2. Я.Долгоржав. Нутгийн өөрөө удирдах ёс. УБ 2000 он
3. С.Төмөр. Монгол улсын үндсэн хуулийн эрхзүй: онол, туршлага, хэтийн төлөв. Нутгийн өөрөө удирдах ёс. УБ 2004 он.
4. М.Сандаг-очир. Нутгийн удирдлага. УБ 2003 он.
5. Гуннар Андерсон. Иргэдийн төлөөлөхүй. Шведийн ардчилсан засаглал. 2005 он
6. Нутгийн өөрийн удирдлагын өнөөгийн байдал: ололт, дутагдал, хандлага. “Онол практикын бага хурал” УБ 2003 он. /Я.Долгоржав. Монгол улсын нутгийн удирдлагын тогтолцоо, ололт, дутагдал. Б.Шатар. Нутгийн өөрийн удирдлагыг бэхжүүлэх нь/
7. Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг дээшлүүлэх нь. Ховд аймаг. Ховд Их сургууль. УБ 2006 он.
8. Монгол улсад нутгийн өөрийн удирдлагын чадавхийг дээшлүүлэх нь. Сургалтын гарын авлага. УБ 2003 он
9. Марк Грамбергер. Иргэн түншлэгч болох нь: Бодлого боловсруулах явцад мэдээлэх, зөвлөлдөх, олон нийтийг оролцуулах. УБ
10. Орон нутгийн хөгжлийн цогцолбор асуудлууд. Зүүнхараа. МУИС-ийн Нийгмийн судалгааны хүрээлэн. 2003 он
11. Орон нутгийн улс төрийн ёсзүйн асуудал. Судалгааны тайлан. 2001 он

12. Орон нутгийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо. Мэрси Кор. ТАН хөтөлбөр. 2007 он
13. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нээлттэй байдал-иргэдийн оролцоо. Судалгааны тайлан. НДЭХ. УБ 2003 он
14. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нээлттэй байдал-иргэдийн оролцоо. Судалгааны тайлан. НДЭХ. УБ 2005 он..
15. Жон Киуага Нсүбүга, Орон нутгийн түвшинд ардчиллыг бэхжүүлэх нь. Судалгааны ажлууд ба төгсгөлийн баримт бичгүүдийн эмхтгэл. АШСТО-ын 5-р бага хурал. УБ 2003 он
16. Жоанна Регулска. Шилжилтийн үед буй орнуудын нутгийн захиргаа ба ТББ хоорондын харилцаа, Ардчилалын төлөөх иргэний нийгмийн түншлэл. Олон улсын иргэний нийгмийн чуулган. УБ 2003 он.
17. С.Дашдаваа. Ц.Заяхүү. Иргэний нийгмийн төлөшилд ТББ-ын гүйцэтгэх үүрэг. 2002 он.
18. Л.Лувсанжамц. Үндэсний ба нутгийн удирдлагын чиг үүргийн зохистой хувиарлалт. ННХ. Бодлогын судалгааны цуврал. 2005.он
19. Г.Жаргал. Орон нутаг эдийн засгаа бие даан хөгжүүлэх боломж, арга зам. ННХ. Бодлогын судалгааны цуврал. 2006.он
20. Бүх шатны хурал, засаг даргийн үйл ажиллаатай холбогдох хууль тогтоомжийн эмхтгэл. 2002 он.
21. Д.Ганхуяг. Монгол менталитет. ННФорумын сайт
22. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал, II товхимол. УТБА. УБ 2000 он.
23. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал. IV товхимол. УТБА. УБ 2002 он. /Я.Бямбаяр. Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг сайжруулах асуудалд, П.Доржсүрэн. Я.Бямбасүрэн. Орон нутагт бодлого боловсруулах асуудалд/
24. Иргэн Таны оролцоо-Ардчиллын баталгаа. УТБА. УБ 2005 он.
25. Хашгирч шаардахаас хариуцлага тооцох хүртэл. Нийгмийн хөгжлийн шинэ хандлага. Дэлхийн хөгжлийн илтгэл. Дэлхийн Банк. 2004 он.
26. Кармен Малена болон бусад. Нийгмийн хариуцлага. Үзэл баримтлал шинээр гарч буй хандлага. Нийгмийн хөгжлийн илтгэлүүд. Нийгмийн оролцоо. Дэлхийн банк. 2004 он.
27. Г.Баясгалан “Засаглалын ил тод байдал” “Сайн засаглал” олон улсын бага хурлын илтгэлүүд. Зориг сан, Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэн, УБ.
28. Д.Нэргүй “Оролцоо-сайн засаглал” “Сайн засаглал” олон улсын бага хурлын илтгэлүүд. Зориг сан, Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэн, УБ.
29. Еоин Янг, Лиза Квин. Үр нөлөө бүхий бодлогын баримт бичиг боловсруулах нь. Төв ба Зүүн Евопын орнуудын бодлогын зөвлөхүүдэд зориулсан гарын авлага.МННХ 2003 он.
30. Open Government. Fostering dialogue with civil society. OECD. 2003.
31. N.Elberg. Kommunaleselbstverwaltung, Lampert, 2001, s-54

Эрхзүйн баримт бичиг, хуулиуд

1. Нутгийн удирдлагын Европын Харти

2. Монгол улсын үндсэн хууль. УБ 1992 он
3. Бүх шатны хурал, засаг даргын үйл ажилагаанд холбогдох эрхзүйн актын эмхтгэл. УБ. 2005 он /бусад хуулиудын талаарх эх сурвалж болов./

Цахим эх сурвалж

1. www.bmz.de. Verwaltungsreform in der deutschen Entwicklungszusammenarbeit Ein Positionspapier des BMZ
2. www.bmz.de. Bundesministerium für wirtschaftliche Zusammenarbeit und Entwicklung Recht – Demokratie – Frieden Politik für Entwicklung
3. www.yahoo.com. Kommunaleselbsverwaltung, Stadt, Oekologie und Nachhaltigkeit
4. www.google.com. <http://www.kas.de/kommunal/e-learning/liste.php?kap=1>
5. www.google.com http://de.wikipedia.org/wiki/Kommunale_Selbstverwaltung